



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/120

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Тулгын 30 айлын орон сууцны орчмын талбайн тохижилт /Жаргалант сум, Баатархайрхан баг/, Ургамал захын дээд талын талбайн тохижилт /Жаргалант сум, Алагтолгой баг/, Төв 4 замын уулзвараас Талын буудлын 3 замын уулзвар хүртэлх замын 2 талын талбайн тохижилт /Жаргалант сум/, баруун бүсийн төв захын өмнөд хэсгийн замын урд, хойд талын тохижилт /Жаргалант сум, Баатархайрхан баг/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Ариунбилэг - Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүдэд: Ц.Цогтбаяр - Жаргалант сумын Засаг даргын орлогч
Д.Мөнгөнхөлөг - Төрийн бус байгууллагын төлөөлөл
Д.Алтангэрэл - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Э.Цолмон - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2.Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ц.Ариунбилэг/-нд үүрэг болгосугай.

3.Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Э.Цолмон /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД